



The Asia Foundation



БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ  
АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

2016



Canada 



**The Asia Foundation**



Sant-Maral Foundation

Энэхүү судалгааг Канадын Гадаад Хэргийн Яамны дэмжлэгтэйгээр хийсэн болно. Судалгааг Азийн Сан, Сант Марал сантай хамтран явуулсан бөгөөд судалгааны үр дүн нь Канадын Засгийн Газар болон Канадын Гадаад Хэргийн Яамны үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

Хавтасны зургийг Б.Уугансүх

# БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

МОНГОЛУЛСАД АРДЧИЛСАН ОРОЛЦООТОЙГООР ТӨРИЙН АЛБАНД  
САЙН ЗАСАГЛАЛ, ИЛ ТОД БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ

2016 он

2016

# АГУУЛГА

Оршил	5
Судалгааны гол үрдүн	6
Судалгааны арга зүй	7
I. Түүврийн тодорхойлолт	9
II. Бизнесийн орчин	15
III. Бизнесийн орчны хүндрэл бэрхшээлүүд	27
IV. Төрийн албан дахь авлига	35
V. Хувийн хэвшил дэх авлига	49
VI. Авлигатай тэмцэх	61
Судалгаанд ашигласан асуулга	71

## ОРШИЛ

2016 оны 10-р сард Азийн сан, Сант Марал сантай хамтран Монголын Бизнес Эрхлэлтийн Орчин дахь Авлигын Нөхцөл Байдлын судалгааг долоо дахь удаагаа нийслэл Улаанбаатар хотод байрладаг аж ахуйн нэгжүүдийн дунд явууллаа.

Бизнес Эрхлэлтийн Орчин дахь Авлигын Нөхцөл Байдлын судалгаа нь Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр Азийн Сангийн хэрэгжүүлж буй “Ардчилсан оролцоотойгоор Төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь” (STEPS) төслийн салшгүй нэг хэсэг юм. Энэхүү судалгаа нь бизнес эрхлэгчдийн ойлголт дээр тулгуурлан бизнесийн орчин дахь авлигын нөхцөл байдал, нөлөөлөл ямар байгааг харуулахаас гадна нь бизнесийн орчин дахь мэдээлэл, хувийн хэвшил болон төр хоорондын харилцаа, шинэчлэл хийх шаардлагатай салбаруудыг ил болгохыг зорьдог. Судалгааг урт хугацааны түрш явуулснаар ойлголт, хандлагад гарч буй өөрчлөлт, чиг байдлыг харьцуулах, үнэлэх боломжтой болдог юм.

Азийн сан АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааг 2012 онд анх удаа явуулж эхэлсэн бөгөөд STEPS төслийн хугацаанд жилд нэг удаагийн давтамжтайгаар нийт гурван удаа хийгдэх юм. Энэ оны судалгаа нь 2016 оны УИХ-ын сонгууль, эдийн засгийн хямрал, төгрөгийн ханшны уналт болон Засгийн Газрын зүгээс эдийн засаг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх санаачлагуудыг хэрэгжүүлэхээр оролдож буй зэрэг томоохон үйл явдлуудын үеэр хийгдлээ. Ийм төрлийн бизнесийн орчинд судалгааны үзүүлэлтүүд бүх төрөлд багасч, сэтгэл ханамж буурсан, хөрөнгө оруулалтын орчин таатай бус болон бизнес эрхлэгчид өөдрөг бус байгааг улам тодотгож өгөв.

Судалгаа нь төр засгийн бодлого тодорхойлогчид, төрийн албан хаагчид болон бизнес эрхлэгчдийн бизнесийн орчин дахь сайн засаглалын арга туршлагын тухай мэдлэгийг нэмэгдүүлэх, цаашид түүнийгээ сайжруулах, хандлагыг өөрчлөх ба авлигаас урьдчилан сэргийлэх мэдээллийг түгээж байдгаараа онцлог юм. Бизнес Эрхлэлтийн Орчин дахь Авлигын Нөхцөл Байдлын судалгаанаас гадна нь Азийн Сангаас мөн үндэсний хэмжээнд Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгааг явуулдаг. Хамтдаа хоёр судалгаа нь Монгол Улс дахь авлигын ерөнхий дүр зургийг харуулахыг зорьдог юм.

## СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

- Эдийн засгийн үзүүлэлтүүд 2016 онд буурсан хэвээр байна:
  - Бизнесийн ерөнхий орчны үнэлгээ 2014 онд -0.73с буурсаар 2015 онд -0.91, 2016 онд -1.0 болсон.  
Хөрөнгө оруулалтын нөхцөл байдал муудсаар байна. 2012 онд компаниудын 11.8 хувь нь нөхцөл байдал
  - муудаж байна гэж мэдээлсэн бол 2016 онд энэ үзүүлэлт 56.7 хувьд хүрлээ.  
Бизнесийн орчинд өөдрөг үзэл нэмэгдэхгүй байна. 2012 оны 12 сард судалгаанд оролцогчдын 57 хувь нь
  - хөрөнгө оруулалтын нөхцөл байдал сайжирна гэсэн хүлээлттэй байсан бол 2016 оны 9 сард ердөө 26.4 хувь нь мөн адил хариулсан байна.
- Татварын өндөр хувь хэмжээ, банкнаас зээл авах боломж, зөвшөөрөл болон лиценз шинээр авах, сунгуулах г.м. асуудлууд бизнест хамгийн их саад болсон хэвээр байна.
- Эдийн засгийн үзүүлэлтүүд буурснаар авлигын ойлголт, төсөөлөлд ч мөн өөрчлөлт гарч байна. Татварын алба, Мэргэжлийн хяналтын газар, орон нутгийн эрх бүхий байгууллага болон гаалийн байгууллага бизнест саад учруулдаг байгууллагуудын тэргүүнд байна.
- Өмнөх жилүүдтэй харьцуулахад үр ашиггүй саад бэрхшээлийг даван туулахад арай бага цаг, нөөц зарцуулсан гэж оролцогчид хариуллаа.
- Судалгаанд оролцогчдын бараг тал нь төрийн салбар дахь авлига "маш их" гэж хариулсан бол оролцогчдын арав гаруй хувь нь хувийн салбарт авлига "маш их" гэж үзсэн (тус бүр 47.9 хувь ба 12.4 хувь).
- Төрийн байгууллагуудаас авлигад хамгийн их автсан нь Татварын алба, Мэргэжлийн хяналтын газар болон Гаалийн алба гэж үзсэн байна.
- Судалгаанд оролцогчдын тал хувь нь (43.6 хувь) төрийн салбар дахь авлига бизнест шууд нөлөөлдөг гэж үзсэн.
- Оролцогчдын талаас илүү хувь нь (53 хувь) улс төр болон гэр бүлийн холбоо нь төрийн байгууллагын тендерийн үр дүнд нөлөөлдөг гэж бодож байна.
- Судалгаанд оролцогчдын 62 хувь нь төрийн үйлчилгээг авлигад хамгийн их өртөмтгий салбар гэж үзсэн хэвээр байна. Үүнийн дараагаар уул уурхайн (48.8 хувь) болон барилга (41,2 хувь) оржээ.
- 2012 оны 12 сард судалгаанд оролцогчдын 19.1 хувь нь бизнесийн салбарын авлигатай тэмцэхэд одоогийн байгаа хууль эрх зүйн орчин "огт үр дүнгүй" гэж бодож байсан бол 2016 оны 9 сард энэ хувь 39.8 болж өсчээ.
- 2012 оны 12 сард судалгаанд оролцогчдын 19.4 хувь нь авлигатай тэмцэх чиглэлээр төр, засгийн авч байгаа алхмууд "огт үр дүнгүй" гэж үзсэн бол 2016 оны 9 сард энэ нь 44.5 хувь болж өссөн байна.
- Оролцогчдын арав хүрэхгүй хувь Авлигатай Тэмцэх Газрын үйл ажиллагааг зэрэг үнэлсэн бол талаас илүү хувь нь сөрөг үнэлгээ өгсөн байна (тус бүр 7.9 хувь ба 52.1 хувь).

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1. Энэхүү тайлан нь авлигын талаархи бизнес эрхлэгчдийн ойлголт, хандлагыг тодорхойлох “Бизнес Эрхлэлтийн Орчин дахь Авлигын Нөхцөл Байдал”-ын судалгааны долоо дахь удаагийн тайлан юм. Энэхүү судалгааг Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр Азийн Сангийн хэрэгжүүлж буй “Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг дэмжих нь” төслийн хүрээнд Сант Марал Сан гүйцэтгэсэн болно.
2. Сант Марал сан мэдээлэл цуглуулах ажлыг 2016 оны 9-р сард явуулсан.
3. Судалгааны зорилтот оролцогчид нь Улаанбаатар хотын бизнес эрхлэгчид. Өмнөх зургаан судалгаагаар цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн ойролцоогоор 1300 компанийн жагсаалтыг гаргасан. Үүнээс 330 компанийг санамсаргүйгээр сонгосон. Бизнесийн том төлөөлөгчид түүвэрт давхцаж байсан бол жижиг болон дунд хэмжээний компаниудын оролцоог эргэлтийн үндсэн дээр хангасан. Судалгаанд 100 хувь Монголын хөрөнгө оруулалттай компаниуд хамрагдсан.
4. Судалгаанд санамсаргүй байдлаар 330 компанийг сонгосон бөгөөд түүвэрлэлтийн явцад гарсан зөрүүг дараах байдлаар тооцоолсон байна: 90/10 хувьд  $\pm 3.2$  хувь, 50/50 хувьд  $\pm 5.4$  хувь, 60/40 хувьд  $\pm 5.3$  хувь ба харьцуулж буй бүлгүүдийг статистикийн ач холбогдлын түвшин 95 хувь байна.
5. Мэдээлэл цуглуулахад өөрөө бөглөх эсвэл ганцаарчилсан ярилцлага хийх аргыг ашигласан.
6. Ярилцлага болон асуулгыг зөвхөн компанийн гүйцэтгэх захирал, эсхүл удирдах түвшний ажилтнаар хязгаарлаж авсан.
7. Одоогийн байдлаар шинэ Засгийн газар яам, агентлагуудын бүтцийн өөрчлөлтийг хийж байгаа. Энэ нь ихэвчлэн Сонгуулийн үе эхлэх бүрт тохиолддог бөгөөд бид нарт ажлаа хийж байхад судалгааны зарим арга хэрэгслүүд хуучирсан болохыг харуулсан.





# ТҮҮВРИЙН ТОДОРХОЙЛОЛТ



# 1. ТҮҮВРИЙН ТОДОРХОЙЛОЛТ


2016 оны бизнесийн орчны түүвэр нь 2014 болон 2015 оны бүтэцтэй төстэй байсан. Судлаачдын багийн ажигласнаар судалгаанд хамрагдсан жижиг болон дунд хэмжээний компаниудын тоо ихээр буурсан байгаа нь өнгөрсөн оны үйл явцтай адил байна.

Сангийн сайд Б.Чойжилсүрэнгийн хагас жилийн тайлангаас үзэхэд 2016 оны эхний хагаст нийт 134,813 бүртгэлтэй компаниудын 66,388 нь үйл ажиллагаагаа түр зогсоосон.


Бидний ажигласнаар түүврийн дараах хэсгүүдэд нөлөөлсөн:

- Судалгаанд хамрагдсан дундаж хэмжээний бизнесүүдийн эзлэх хувийн жин 2015 оны 38.2 хувиас 2016 онд 33.6 хувь болж буурсан (Зураг 1.3). Жижиг бизнесүүдийн эзлэх хувь хэмжээ бага зэрэг нэмэгдсэн боловч тэдгээрийн 70 орчим хувь шинэ бизнес байв.
- Нийт түүврийн хэмжээнд 2000-2006 онд бүртгэгдсэн компаниудын эзлэх хувь буурсан хэвээр байна. 2000 оноос өмнө байгуулагдсан хуучны компаниудын түүвэрт эзлэх хувь нэмэгдсэн байна. 2007 оноос хойш байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийн түүвэрт эзлэх хувь аажмаар нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байсан боловч ямар ч өөрчлөлт гараагүй. Энэ нь эдийн засгийн өсөлт бага буюу зогсонги байгаатай холбоотой гэж үзэж байна (Зураг 1.4).
- Жендерийн харьцаа өмнөх түүврүүдтэй ижил байна (Зураг 1.5)
- Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн ялгаа нь ихэвчлэн салбараар байна. Уламжлал ёсоор уул уурхай болон барилгын салбарт эрэгтэйчүүд голлож байна (Зураг 1.6).
- Том болон дунд хэмжээний бизнесүүдийн ихээхэн хэсэг нь эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүдийг авч ажиллуулдаг. Жижиг бизнесийн орчинд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийг аль нэгийг нь илүү авч ажиллуулдаг эсвэл жендерийн ижил харьцаатай компаниудын хувь хэмжээ адил байсан (Зураг 1.7).


Зураг 1.1: Газар зүйн байршил




Зураг 1.2: Үйл ажиллагааны чиглэл




Зураг 1.3: Бизнесийн үйл ажиллагааны хэмжээ



Зураг 1.4: Байгуулагдсан он




Зураг 1.5: Компанийн ажиллагсдын жендэрийн харьцаа




Зураг 1.6: Жендерийн харьцаа (үйл ажиллагааны чиглэлээр)

2016 оны 9 сар



Зураг 1.7: Жендерийн харьцаа (Компанид ажиллагсдын тоо, бизнес хөрөнгийн хэмжээ)




# БИЗНЕСИЙН ОРЧИН



## 2.БИЗНЕСИЙН ОРЧИН

Бизнесийн орчны эерэг үнэлгээ буурсаар 2016 оны 9 сард бизнесийн орчны сэтгэл ханамж судалгаа хийгдсэн бүх цаг үеийн хамгийн доод түвшин хүрч оролцогчдын дөрөвний нэг нь "сэтгэл маш хангалуун бус" гэж хариулжээ (Зураг 2.1).

Зураг 2.1: Бизнесийн орчин дахь сэтгэл ханамж: Нийт




	12 сар 2012	5 сар 2013	10 сар 2013	4 сар 2014	9 сар 2014	9 сар 2015	9 сар 2016
■ Мэдэхгүй	5.5%	8.5%	7.0%	5.2%	6.1%	3.3%	1.8%
■ Огт сэтгэл хангалуун бус	17.6%	18.5%	23.9%	20.0%	17.3%	19.7%	24.8%
■ Бага зэрэг сэтгэл хангалуун бус	49.7%	52.7%	48.5%	62.4%	56.1%	63.0%	61.2%
■ Бага зэрэг сэтгэл хангалуун	24.8%	20.3%	19.4%	12.4%	18.8%	13.3%	11.8%
■ Маш сэтгэл хангалуун	2.4%	0.0%	1.2%	0.0%	1.8%	0.6%	0.3%




Сэтгэл ханамжийн түвшин нь Монголын эдийн засаг дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын түвшинтэй хамааралтай байгааг харуулж байна (Зураг 2.2, Зураг 2.3). Сангийн сайд Б. Чойжилсүрэнгийн танилцуулсан статистикаас харахад гадаадын шууд хөрөнгө оруулалт 2012 оны 4407,8 сая ам.доллар байсан бол 2014 онд 276 сая ам. доллар болж бууран 2016 оны 9 сарын байдлаар 35.2 сая ам.доллар болжээ. “Бизнес Эрхлэлтийн Орчин дахь Авлигын Нөхцөл Байдал”-ын судалгаанд бизнесийн орчны сөрөг үнэлгээ 2012 онд -0.58-аас 2014 онд -0.95 болсон ба 2016 онд -1 болж бараг хоёр дахин нэмэгдсэн байна. Түүврийг 100 хувь Монголын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдээс бүрдүүлсэн ба дотоодын аж ахуйн нэгжүүд гадаадын хөрөнгө оруулалтаас ихээхэн хамааралтай байгааг судалгааны дүн харуулж байна.

Зураг 2.2: Бизнес эрхлэлтийн орчны үнэлгээний баланс (-2-оос "Огт хангалуун биш" +2 "Маш хангалуун" хүртэл)



Зураг 2.3: Гадаадын шууд хөрөнгө оруулалт<sup>1</sup> (2011 оноос 2016 оны эхний хагас)



<sup>1</sup> Эх сурвалж: Сангийн сайд Б. Чойжилсүрэнгийн илтгэл ("Өнөөдөр" 2016 оны 8 сарын 10)


Бизнесийн орчинд сэтгэл ханамж хамгийн бага байгаа нь жижиг бизнесүүд бөгөөд 2016 онд тэдгээрийн 26.7 хувь нь "сэтгэл огт хангалуун биш" гэж хариулсан байна (Зураг 24А). Монгол улсад ажил эрхлэлтийг дэмжигч гол хүчин зүйл нь жижиг бизнес эрхлэгчид гэж үздэг бөгөөд жижиг бизнес эрхлэлтийг дэмжилгүйгээр ажилгүйдлийг шийдвэрлэхэд их бэрхшээлтэй байх болно.

Одоог хүртэл асуудлыг шийдэх үндсэн арга нь төрийн салбарыг өргөжүүлэх байсан юм. Ингэх явцдаа ихэвчлэн хувийн хэвшлийн үйл ажиллагааг хязгаарлах эсвэл шударга бус өрсөлдөөний аргаар явуулдаг талаар мэргэжлийн ассоциаци, холбоод мэдээлсээр ирсэн билээ. Судалгааны түүврийн тайлбар хэсэгт дурдсанчлан ийм тохиолдолд жижиг бизнесүүд гол хохирогчид болсоор байна.

Дунд хэмжээний бизнесүүдийн дунд "огт сэтгэл хангалуун биш" байгаа хэсэг 2015 онд 15.9 хувь байснаас 2016 онд 23.4 хувь болж өссөн байна (Зураг 24б). 2015 онтой харьцуулахад том бизнесүүдийн хүрээнд бизнесийн орчинд "сэтгэл бага зэрэг хангалуун" мөн "огт сэтгэл хангалуун биш" хүмүүс арай өндөр хувийг эзэлж байна (Зураг 24с). 2014 онд том бизнесүүдийн 17 хувь нь бизнесийн орчинд сэтгэл хангалуун байсан бол 2015 онд 28 хувь болж өссөн, харин "огт сэтгэл хангалуун биш" хэсэг 2014 онд 20 хувиас 2015 онд 32 хувь болж өсжээ. Гэсэн хэдий ч 2016 оны 9 сард сэтгэл ханамжийн түвшин буцаж 2014 оны 9 сарын түвшинд ойртсон байна.


Зураг 24: Бизнесийн орчинд сэтгэл хангалуун байдал:

а) Бизнесийн орчинд сэтгэл хангалуун байдал: Жижиг компани




	12 сар 2012	5 сар 2013	10 сар 2013	4 сар 2014	9 сар 2014	9 сар 2015	9 сар 2016
■ Мэдэхгүй	4.7%	10.5%	7.6%	4.3%	7.1%	5.3%	3.0%
■ Огт сэтгэл хангалуун бус	19.3%	21.0%	22.8%	19.3%	15.6%	18.7%	26.7%
■ Бага зэрэг сэтгэл хангалуун бус	55.3%	42.0%	48.7%	64.0%	53.9%	66.0%	60.0%
■ Бага зэрэг сэтгэл хангалуун	18.0%	26.6%	20.3%	12.4%	21.4%	10.0%	9.7%
■ Маш сэтгэл хангалуун	2.7%	0.0%	0.6%	0.0%	1.9%	0.0%	0.6%

*б) Бизнесийн орчинд сэтгэл хангалуун байдал: Дунд хэмжээний компани*




*с) Бизнесийн орчинд сэтгэл хангалуун байдал: Том компани*



Бизнесийн орчны үнэлгээнд эмэгтэйчүүд олноор ажилладаг компани болон нийт компаниудын хооронд ямар нэгэн алгаа харэгдсангүй.

Зураг 2.5: Бизнес эрхлэлтийн орчны үнэлгээний баланс (-2-оос "Огт хангалуун биш" +2 "Маш хангалуун" хүртэл): эмгэгтэйчүүд олноор ажилладаг компани болон нийт компаниудыг харьцуулсан байдлаар




Хөрөнгө оруулалтын нөхцөл байдлын үнэлгээ сүүлийн 6 сарын хугацаанд буурсан хэвээр байна (Зураг 2.6). “Нөхцөл байдал муудаж байна” гэсэн үнэлгээ 2012 оны 12 сард ердөө 11.8 хувь байсан бол 2016 оны 9 сард 56.7 хувьд хүрч (Зураг 2.6а).


Үнэлгээг аж ахуйн нэгжүүдийн хэмжээгээр авч үзвэл 2016 онд нөхцөл байдал муудаж байна гэж үзэх компаниудын тоонд ялгаа бараг байхгүй байна. Харин жижиг болон дунд компаниуд илүүтэйгээр хөрөнгө оруулалтын нөхцөл байдал сүүлийн 6 сард муудсан байна гэж мэдээлжээ. Хөрөнгө оруулалтын өнгөрсөн зургаан сарын нөхцөл байдал болон ирэх зургаан сарын хүлээлт хоёрын аль алинд нь 2012 болон 2016 онуудын хооронд томоохон сөрөг өөрчлөлт гарсан байна.

Зураг 2.6: Сүүлийн зургаан сарын хөрөнгө оруулалтын нөхцөл байдал:


а) Нийт




б) Жижиг компани



## с) Дунд хэмжээний компани



## d) Том компани




Ирэх жил хямрал дуусч эдийн засаг сэргэж эхэлнэ гэж Засгийн Газар зарласны дараа бизнесийн орчны хөрөнгө оруулалтын талаарх өөдрөг үзэл бага зэрэг нэмэгдсэн бололтой. Хэдийгээр оролцогчдын 17.6 хувь ирээдүйн хөрөнгө оруулалтын төлөв байдлын талаарх ойлголтгүй байгаа ч “нөхцөл байдал муудах болно” гэж хариулах хүмүүсийн тоо 2015 онд 18.5 хувиас 2016 онд 14.8 хувь болж бага зэрэг буурсан байна (Зураг 2.7a).


Ирээдүйн төлвийн талаар хамгийн өөдрөг үзэлтэй хэсэг нь том аж ахуйн нэгжүүд байна. 2015 оны 24.1 хувьтай харьцуулахад 2016 онд тэдгээрийн ердөө 9.3 хувь нь байдал муудах болно гэж үзжээ. Харин дунд хэмжээний аж ахуйн нэгжүүд өөдрөг бодолгүй байна. Өнгөрсөн онд 16.7 хувь байсан нь бага зэрэг нэмэгдэж 18 хувь нь ирэх зургаан сарын хугацаанд нөхцөл байдал муудна гэж хариулжээ. Жижиг компаниудын хувьд өнгөрсөн оны 18 хувьтай харьцуулахад энэ жил 14.5 хувь нь нөхцөл байдал муудна гэсэн бодолтой байна. Том бизнес эрхлэгчдээс илүүтэйгээр жижиг бизнес эрхлэгчид ирээдүйн төлөв муудна гэж үзэж байна.

Зураг 2.7: Ирэх 6 сарын хөрөнгө оруулалтын төлөв


а) Хөрөнгө оруулалтын ирээдүйн төлөв: Нийт



## b) Хөрөнгө оруулалтын ирээдүйн хүлээлт: Жижиг компани




## c) Хөрөнгө оруулалтын ирээдүйн төлөв: Дунд хэмжээний компани






d) Хөрөнгө оруулалтын ирээдүйн төлөв: Том компани




Зураг 2.8: Сүүлийн 6 сарын хөрөнгө оруулалтын нөхцөл (хүйсээр)



Ирээдүйн хөрөнгө оруулалтын төлөв байдлын талаарх эерэг хүлээлт бүх бүлгүүдийн хувьд ижил байв (Зураг 2.9). Гэвч эрэгтэйчүүдийг олноор ажилладаг компаниуд бусад хоёр бүлгүүдээс илүүтэйгээр хөрөнгө оруулалтын нөхцөл байдал "муудна" гэж үзсэн (харгалзан 18.4 хувь, 10 хувь ба 14.5 хувь).

Зураг 2.9: Ирэх 6 сарын хөрөнгө оруулалтын хүлээлт (хүйсээр)



# БИЗНЕСИЙН ОРЧНЫ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛҮҮД




### 3. БИЗНЕСИЙН ОРЧНЫ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛҮҮД

Судалгаа хийгдэж эхэлсэн 2012 оноос хойш бизнес эрхлэх, хөрөнгө оруулалтад саад болж байгаа үндсэн гурван хүчин зүйл хэвээр байна. Эдгээр нь өндөр татвар, зээлийн хүртээмж болон авах боломж, лиценз ба зөвшөөрөл шинэчлэх (Зураг 3.1). Судалгааны түршид өндөр татвар хамгийн ихээр дурдагдах бэрхшээл хэвээр байхад нөгөө хоёр бэрхшээлийн эрэмбэ өөрчлөгдсөн байна. 2016 онд өмнөх онуудаас хамаагүй илүү оролцогчид (63.6 хувь) "өндөр татвар"-ыг хөрөнгө оруулалтын гол бэрхшээл гэж үзэж байна. Зөвшөөрөл болон лицензийг 2012 онд оролцогчдын 33.6 хувь бэрхшээл гэж үзэж байсан бол тогтвортой буурсаар 2016 онд 17 хувь болсон байна. Зээл авах боломж эсрэг үзүүлэлттэй байсан ба 2012 онд 21.5 хувиас эхэлж 2016 онд 26.1 хувьд хүрчээ.

2016 онд "өндөр татвар" нь үндсэн бэрхшээл гэж тооцогдох хамгийн өндөр хэмжээ буюу 63.6 хувьд хүрсэн байна. Үүн дээр нэмэх нь зээлийн хүртээмжгүй байдал нь Монголын бизнес эрхлэгчдэд санхүүгийн хүндрэл бэрхшээлийг учруулж байна.

Албан болон албан бус төлбөр, түр зуурын болон байнгын хориг арга хэмжээ, хязгаарлалт гэх мэт бэрхшээлийн үнэлгээнд 2012-2016 оны хооронд эерэг хандлага ажиглагдсан.

Зураг 3.1: Хөрөнгө оруулалтын үндсэн бэрхшээлүүд



## Хүснэгт 1: Бизнесийн үндсэн бэрхшээлүүд

№		12.2012	03.2013	10.2013	04.2014	09.2014	09.2015	09.2016
1	Өндөр татвар	58.2%	49.7%	56.1%	52.4%	50.0%	50.0%	63.6%
2	Зээл авах боломж	21.5%	27.3%	21.8%	27.0%	25.2%	26.4%	63.6%
3	Зөвшөөрөл, лиценз олголт ба сунгалт	33.6%	21.8%	25.5%	27.3%	16.7%	20.9%	17.0%
4	Бусад компаниудаас үзүүлж байгаа хүчтэй өрсөлдөөн	11.2%	13.6%	14.8%	26.7%	20.6%	18.8%	16.1%
5	Хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал /хомсдолтой/	9.7%	10.6%	10.6%	14.2%	11.5%	10.6%	12.1%
6	Албан хураамж	16.1%	10.6%	9.1%	12.4%	9.7%	10.3%	11.8%
7	Албан бус хураамж	17.0%	9.7%	11.2%	9.7%	11.2%	7.6%	11.2%
8	Түр зуурын хориг, саад	15.5%	15.8%	18.8%	12.1%	13.6%	10.9%	10.9%
9	Ажиллах хүчний мэргэжлийн чадвар хангалтгүй	23.3%	20.3%	24.2%	16.7%	16.4%	13.3%	10.9%
10	Зах зээлийн судалгаа хангалттай бус	4.2%	7.0%	10.3%	10.3%	9.4%	9.7%	10.3%
11	Тээврийн хүртэмж, үнэ	13.3%	13.6%	10.3%	3.6%	8.8%	4.5%	8.8%
12	Байнгын хориг, саад	10.9%	8.8%	10.6%	7.9%	7.6%	6.1%	5.8%
13	Мэдээллийн хүртээмж болон чанар	10.0%	4.8%	6.7%	8.2%	2.4%	5.2%	5.2%
14	Стандартчилалын шаардлага	6.1%	10.6%	5.5%	8.2%	10.9%	10.9%	4.5%
15	Менежментийн сургалт хангалттай бус	4.2%	3.6%	3.9%	3.9%	2.7%	2.4%	2.4%
	Мэдэхгүй/Хариулаагүй	2.7%	4.2%	2.7%	2.7%	1.2%	2.7%	1.8%
	Бусад	1.2%	0.9%	6.1%	3.6%	9.4%	7.6%	1.5%
	Бэрхшээл байхгүй	0.6%	3.3%	1.2%	1.2%	2.7%	4.8%	1.5%

Татварын алба, Мэргэжлийн хяналтын газар, нутгийн захиргааны байгууллага болон гааль бизнест хамгийн ихээр хүндрэл учруулдаг байгууллагуудад тооцогдож байна (Хүснэгт 3.2). 2012 оноос эхлэн МХГ-ын үнэлгээ бага багаар сайжирсан нь судалгаанд оролцогчдын 28 хувь саад гэж үзэж байсан бол 2016 онд 17.3 хувь болж буурснаас харагдаж байна. Гааль болон татварын албаны бэрхшээлийн зэрэглэл судалгааны түршид их, бага хэмжээгээр ижил түвшинд байсан бол орон нутгийн захиргааны байгууллага 2015 онд 6.7 хувиас 2016 онд 11.5 хувь болж нэмэгдсэн байна. Сонгуулийн дараа ихэвчлэн төр захиргааны байгууллагуудад томоохон шилжилт хөдөлгөөн, цомхтгол хийгддэг нь нөлөөлсөн байж болзошгүй.

Дараах жагсаалт нь 2012-оос 2016 оны хоорондох нийлбэр түүвэр дээр үндэслэн салбаруудын хувьд хамгийн их бэрхшээл учруулдаг байгууллагуудыг харуулж байна (Хүснэгт 2).

#### Хүснэгт 2:

Үйлчилгээ	→ Цагдаа	8.0%
	→ Хоттохижилтын газар	2.6%
Худалдаа	→ Гаалийн алба	25.3%
Барилга	→ Татварын алба	38.4%
Уул уурхай	→ Орон нутгийн эрх барих байгууллага	25.5%
Хөдөө аж ахуй <sup>2</sup>	→ Мэргэжлийн Хяналтын Байгууллага	34.5%
Хөдөө аж ахуй	→ Эрүүл ахуйн байгууллага	6.9%

#### Хүснэгт 3: Бизнест хүндрэл учруулж буй төрийн байгууллагууд

	2012 – 12 сар	2013 – 3 сар	2013 – 10 сар	2014 – 4 сар	2014 – 9 сар	2015 – 9 сар	2016 – 9 сар
Татварын алба	35.4%	29.1%	26.7%	32.4%	30.6%	37.6%	35.5%
Мэргэжлийн хяналтын газар	28.0%	23.6%	19.1%	21.2%	18.2%	18.8%	17.3%
Орон нутгийн захиргаа	9.9%	10.6%	7.3%	11.2%	7.6%	6.7%	11.5%
Гааль	15.2%	13.3%	13.6%	11.8%	11.8%	12.1%	10.9%
Газар надастрын алба	6.2%	5.8%	5.8%	7.9%	6.1%	2.1%	4.5%
Цагдаагийн байгууллага	8.1%	5.2%	3.3%	2.7%	6.1%	3.0%	3.6%
Хот тохижилтын газар	1.2%	1.2%	1.2%	2.4%	2.7%	3.3%	0.9%
Ариун цэврийн алба	2.5%	2.7%	0.6%	3.3%	1.5%	0.6%	0.9%
Бусад	3.7%	5.8%	4.5%	3.3%	5.5%	7.9%	3.9%
Мэдэхгүй	13.7%	20.0%	16.1%	23.0%	24.8%	21.5%	26.7%


<sup>2</sup> Судалгаанд хөдөө аж ахуйн түүвэр маш бага учраас мэдээллийн тогтворгүй байдлыг үүсгэж болзошгүй. Тооцоог нэгтгэсэн түүврээр хийсэн тул бид бодитой үр дүн гарна гэж найдаж байгаа ч дэд түүврийн түвшинд чиг хандлагын шугам гаргахад хангалтгүй байна.

*Хүснэгт 4: Бизнес түндрэл бэрхшээл учруулж байгаа төрийн байгууллагууд:  
2012 - 2016 оны хоорондох нэгдсэн түүвэр (компанийн үйл ажиллагааны чиглэлээр)*

	Үйлчилгээ	Худалдаа	Үйлдвэрлэл	Барилга	Уул уурхай	ХХА	Бусад
Мэргэжлийн хяналтын газар	14.7%	20.0%	26.0%	31.0%	29.1%	34.5%	13.3%
Газар кадастрын алба	4.8%	3.6%	4.3%	11.3%	9.1%	10.3%	3.8%
Цагдаагийн байгууллага	8.0%	2.9%	1.5%	14%	1.8%	0.0%	9.5%
Татварын алба	28.4%	33.0%	35.6%	38.4%	32.7%	24.1%	33.3%
Гааль	10.3%	25.3%	8.3%	6.7%	9.1%	6.9%	2.9%
Хот тохижилтын газар	2.6%	1.8%	2.0%	1.1%	0.0%	0.0%	0.0%
Ариун цэврийн алба	2.7%	1.5%	1.8%	0.0%	0.0%	6.9%	0.0%
Орон нутгийн захиргаа	9.0%	7.1%	6.1%	12.0%	25.5%	13.8%	8.6%
Бусад	6.1%	1.8%	6.3%	4.6%	5.5%	6.9%	6.7%
Мэдэхгүй	26.2%	19.7%	23.0%	14.8%	15.5%	20.7%	27.6%


Компаниуд үр ашиггүй бэрхшээлийг шийдэхэд зарцуулдаг цаг хугацаанд зарим нэг эерэг өөрчлөлт гарсан байна (Зураг 3.2). Үр ашиггүй бэрхшээлийг шийдвэрлэхэд цаг хугацааныхаа 50-аас дээш хувийг зарцуулдаг хүмүүсийн тоо 2015 онд 14.5 хувь байснаас 2016 онд 12.1 хувь болж бага зэрэг буурсан байна. Харин 2015 онд судалгаанд оролцогчдын 14.5 хувь нь үр ашиггүй бэрхшээлийг шийдвэрлэхэд ямар ч цаг хугацаа зарцуулдаггүй байсан бол 2016 онд энэ нь 19.7 хувь болж өссөн байна.

Зураг 3.2: Үр ашиггүй бэрхшээлийг шийдэхэд зарцуулдаг цаг хугацаа



Үр ашиггүй бэрхшээлд зарцуулж байгаа нөөцийн хувьд өмнөх жилүүдийн "мэдэхгүй байна" гэсэн хариултын өндөр хувьтай харьцуулахад энэхүү асуудлаар илүү их оролцогчид өөрсдийн санал бодлоо илэрхийлсэн байна. Судалгаанд оролцогчдын тогтмол 9-10 орчим хувь нь үр ашиггүй бэрхшээлд өөрсдийн нөөцийн 25 гаруй хувийг зарцуулдаг тухай мэдээлдэг байв. Гэвч нөөцийн 10 хүртэлх хувийг зарцуулдаг гэх оролцогчдын тоо нэмэгдсэн нь 2015 онд 30.6 хувь байснаа 2016 онд 38.8 хувь болсноос харагдаж байна (Зураг 3.3).


Зураг 3.3: Үр ашиггүй бэрхшээлийг шийдэхэд зарцуулдаг хөрөнгө мөнгө






Компаниудын нөөц болон цагийн менежментийг хүйсийн харьцаагаар нь авч үзвэл эмэгтэйчүүд олноор ажилладаг компаниудын гүйцэтгэл илүү сайн байгаа нь харагдаж байна (Зураг 3.4 ба 3.5). Эдгээр компаниуд дэмий зарцуулсан цаг хугацаа болон нөөц багатай байна. Гэвч энэ ялгаатай байдал нь хүйсийн харьцааны биш бүтэц болон салбарын ялгаанаас үүдэлтэй байж болох юм. Уул уурхай болон барилгын салбарууд эрэгтэйчүүд олноор ажилладаг бөгөөд бөгөөд дунд болон том компаниудад эрэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж байна (Зураг 1.6 болон Зураг 1.7).

Зураг 3.4: Танай байгууллагын удирдлага үйлдвэрлэлийн бус асуудлуудыг жич: зөвшөөрөл, лиценз шинэчлэх буюу шинээр авах, албан ёсны хариу хүлээх гэх мэт, шийдвэрлэхэд ажлын цагийн хэдэн хувийг зарцуулдаг вэ? (хүйсээр)



Зураг 3.5: Үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд байгууллагын нөөцийн хэдэн хувийг үр ашиггүй зарцуулдаг вэ? (Компанид ажиллагсдын жендерийн харьцаагаар)




# ТӨРИЙН АЛБАН ДАХЬ АВЛИГА



## 4. ТӨРИЙН АЛБАН ДАХЬ АВЛИГА

2016 оны 9 сард төрийн албан дахь авлигын түвшний үнэлгээ өндөр хэвээр бөгөөд 2015 оны 9 сарын түвшинтэй ижил байна (Зураг 4.1). Судалгаанд оролцогчдын бараг тал нь төрийн албанд авлига "маш их" байгаа гэж үзэж байна (47.9 хувь). Гэсэн хэдий ч судалгаанд оролцогчдын аравны нэг нь мэдэхгүй гэж хариулжээ (9.4 хувь).


Зураг 4.1: Таны бодлоор төрийн албанд авлига хэр их байна вэ?



Төрөл	12 сар 2012	5 сар 2013	10 сар 2013	4 сар 2014	9 сар 2014	9 сар 2015	9 сар 2016
Мэдэхгүй	7.3%	11.8%	4.8%	9.1%	11.2%	6.7%	9.4%
Байхгүй	0.9%	0.0%	0.6%	0.6%	0.6%	0.3%	0.3%
Бага зэрэг	8.8%	10.0%	10.6%	10.3%	11.2%	9.4%	8.8%
Нилээд	40.9%	37.6%	37.3%	36.1%	38.5%	33.9%	33.6%
Маш их	42.1%	40.6%	46.7%	43.9%	38.5%	49.7%	47.9%


"Өнгөрсөн сард" өөрийн биеэр авлигын гэрч болсон оролцогчдын тоо ихээхэн буурч 2015 оны 9 сард 14.2 хувь байснаас 2016 онд 9 сард 8.8 хувь болсон байна (Зураг 4.2). Гэвч "жилийн өмнө" авлигын тохиолдлыг ажигласан гэх оролцогчдын тоо 12.7 хувиас 21.5 хувь болж нэмэгдсэн байна. Эдгээр өөрчлөлтүүд нь сүүлийн жилүүдэд эдийн засаг үйл ажиллагаа багассантай холбоотой байж болох юм. Уг асуултанд хариулахад хүндрэлтэй байснаас үүдэн судалгаанд оролцогчдын гуравны нэг нь дээрх асуудлаар ямар ч ойлголтгүй гэж хариулсныг тэмдэглэх нь зүйтэй.

Зураг 4.2: Танай салбарт төр болон хувийн компанийн харилцаанд авлигын чанартай зүйл байгааг та хамгийн сүүлд хэзээ ажигласан бэ?



Төрийн байгууллагын тендер болон гэрээ байгуулах явц дахь авлигын тохиолдолд ижил төстэй бууралт ажиглагдсан (Зураг 4.3). Тендер, гэрээ байгуулах явцад авлига маш их гэж үзэх хүмүүсийн тоо 38.2 хувиас 30.6 хувь болж буурсан байна. Гэвч авлигын талаар "мэдэхгүй байгаа" хүмүүсийн тоо 16.7 хувиас 23.6 хувь болж өссөн байна. Эдгээр өөрчлөлтүүд эдийн засгийн үйл ажиллагаа нийтдээ багассантай холбоотой байх магадлалтай юм.


Зураг 4.3: Төрийн байгууллагын тендер болон гэрээ байгуулах үйл явцад авлига хэр их байна гэж та боддог вэ?



Судалгаанд оролцогчид засгийн газрын агентлагуудыг авлигад хамгийн их өртсөн байдлаар нь эрэмбэлэхэд (Зураг 44) гарсан дүр зураг нь бизнес эрхлэгчдэд бэрхшээл учруулж байгаа байгууллагуудын жагсаалттай нягт хамааралтай харагдаж байна (Зураг 3.2). Татварын алба хамгийн өндөр үнэлгээ буюу 29.1 хувиар жагсаалтын эхэнд харин Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 27.6 хувиар хоёрт байна. Эдгээр байгууллагууд нь хоёр төрлийн жагсаалтын аль алиныг нь тэргүүлж байна.


Зураг 44: Төрийн байгууллага болон үйлчилгээний авлигын үнэлгээ:

Таны бодлоор бизнесийн үйл ажиллагаа явуулахад доорх төрийн үйлчилгээ, агентлаг уудаас аль нь хамгийн их авлигад өртсөн бэ? (Гурван хариултыг зөвшөөрсөн)



Төрийн салбар дахь авлига бизнест нь шууд нөлөөлдөг гэж үзэх оролцогчдын тоо шууд нөлөөгүй гэж үздэг оролцогчдын хувь хэмжээнээс илүү өндөр байдаг хэвээр байна (43.6 хувь ба 41.5 хувь; Зураг 4.5). Аль аль хариултууд 2015 онтой харьцуулахад бага зэрэг нэмэгдсэн, харин "мэдэхгүй" хариултын тоо буурсан байна.


Зураг 4.5: Төрийн албан дахь авлига танай бизнест шууд нөлөөлж байна уу?



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад "бага зэрэг" нөлөөлсөн гэх оролцогчдын хувь 20.7 хувиас 2016 оны 9 сард 27.8 хувь болж өссөн байна (Зураг 4.6). Энэхүү өсөлт нь төрийн албан дахь авлига бизнесийн үйл ажиллагаанд "зарим талаар" нөлөөтэй гэж хариулах оролцогчдын тоо бүүрснаас үүдэлтэй. Авлига "маш их" нөлөөлдөг гэж хариулсан оролцогчдын тоонд томоохон өөрчлөлт гараагүй ба 28.5 хувьтай байна.




Зураг 4.6: Хэрвээ тийм бол хэр их нөлөөлж байна вэ?




Их Авлига буюу дээд түвшний авлигын нөлөөллийн үнэлгээнд 2015 болон 2016 оны судалгааны хооронд ямар нэгэн ялгаа байхгүй байна (Зураг 4.7). 2015 болон 2016 оны судалгаанд оролцогчдын аравны нэг нь Их Авлига бизнест ихээр нөлөөлж байна гэж үзсэн (11.5 хувь ба 11.5 хувь). 2015 болон 2016 оны оролцогчдын гуравны нэг нь тэдэнд "зарим талаар" буюу дунд хэмжээнд нөлөөтэй гэж хариулсан (34.2 хувь ба 34.5 хувь). 2016 оны судалгааны үр дүнг компанийн хэмжээгээр хүснэгтлэн авч үзвэл нөхцөл байдал өөр байна (Зураг 4.8).

Компанийн хэмжээ болон Их авлигын нөлөө хоёрын хооронд шууд хамаарал байна. Том компаниуд жижиг компаниудыг бодвол Их авлига илүү их хохиролтой гэж үзжээ.

Зураг 4.7: Таны бодлоор Их авлига буюу дээд түвшний авлига бизнест хэр зэрэг нөлөөлж байна вэ?



Зураг 4.8: Таны бодлоор Их авлига буюу дээд түвшний авлига Таны бизнест хэр зэрэг нөлөөлж байна вэ? (2016 оны 9 сар)




Монголд авлига хэр зохион байгуулалттай байдаг талаар өнгөрсөн онтой харьцуулахад бага зэрэг өөрчлөлт гарсан байна (Зураг 4.9). 2015 онд судалгаанд оролцогчдын 21.8 хувь нь авлига хувийн харилцааны замаар илүү тархдаг гэж үзэж байсан нь 2016 онд 17.9 хувь болж буурсан байна. Хэдий тийм боловч авлигыг хувийн харилцаа болон зохион байгуулалттай арга замын аль алианаар нь тархдаг хэмээн хариулсан хүмүүсийн тоо 2015 оны 21.5 хувиас 2016 онд 26.4 хувь болж өссөн байна.

Компаниудын хэмжээгээр нь харахад (Зураг 4.10) дунд болон том хэмжээний компаниудын бараг тал нь авлигыг илүү зохион байгуулалттай арга замаар тархдаг гэсэн итгэл үнэмшилтэй байна. Жижиг болон дунд хэмжээний компаниудын тавны нэг орчим хувь нь авлигыг хувийн харилцааны түвшинд илүү их тархдаг гэж үзэж байхад том хэмжээний компаниудын ердөө аравны нэг нь ижил бодолтой байна.


Зураг 4.9: Таны бодлоор төрийн авлигын сүлжээ голдуу хувь хүмүүсийн хоорондын харилцааны хүрээнд тархаж байна уу, эсвэл зохион байгуулалттай бүлэглэлийн хэмжээнд очсон байна уу?

- Голдуу зохион байгуулалттай бүлэглэлийн хэмжээнд очсон байна
  - Голдуу хувь хүмүүсийн хоорондын харилцааны хүрээнд
- Хоёр хэлбэр тэнцүү байдалтай байна
  - Мэдэхгүй/Хариулаагүй



Зураг 4.10: Таны бодлоор төрийн албан дахь авлига нь голдуу хувь хүмүүсийн хоорондын харилцааны хүрээнд тархаж байна уу, эсвэл зохион байгуулалттай бүлэглэлийн хэмжээнд очсон байна уу? (2016 оны 9 сар)


- Голдуу зохион байгуулалттай бүлэглэлийн хэмжээнд очсон байна
- Хоёр хэлбэр тэнцүү байдалтай байна
- Голдуу хувь хүмүүсийн хоорондын харилцааны хүрээнд
- Мэдэхгүй/Хариулаагүй




Судалгаанд оролцогчдын дунджаар дөрөвний нэг хувь нь төрийн байгууллагын тендерт оролцож байсан тухай мэдээлсэн (Зураг 4.11). 2016 оны 9 сард судалгаанд хамрагдсан компаниудын 26.4 хувь нь оролцсон байна. Эдгээр үр дүнг компаниудын хэмжээгээр хүснэгтлэхэд том компаниудын 48.1 хувь, жижиг компаниудын ердөө 17.6 хувь нь тендерт оролцсон болохыг харуулж байна (Зураг 4.12). Мөн түүнчлэн эрэгтэйчүүд олноор ажилладаг компаниудын ихээхэн хэсэг нь тендерт оролцсон гэж мэдээлсэн байна (Зураг 4.13).

2016 онд судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь (53 хувь) тендерийн үр дүнд улс төрийн намын гишүүнчлэл болон гэр бүл, ах дүү хамаатан садны харилцаа нөлөөлдөг гэж үзэж байна (Зураг 4.14). Бизнесийн орчин дахь авлигын түвшний өөрчлөлтийн үнэлэхэд оролцогчдын 35.7 хувь өнгөрсөн гурван жилийн хугацаанд авлига нэмэгдсэн, харин 20.3 хувь нь авлига буурсан гэж үзэж байна (Зураг 4.15).


Зураг 4.11: Танай компани төрийн байгууллагын тендерүүдэд оролцдог уу?




Зураг 4.12: Танай компани төрийн байгууллагын тендерүүдэд оролцдог уу? (компанийн хэмжээгээр)



Зураг 4.13: Танай компани төрийн байгууллагын тендерүүдэд оролцдог үү? (хүйсээр)




Зураг 4.14: Таны бодлоор улс төр, гэр бүл, ах дүү, хамаатан садны харилцаа тендерийн үр дүнд нөлөөлдөг үү?




	5 сар 2013	10 сар 2013	4 сар 2014	9 сар 2014	9 сар 2015	9 сар 2016
■ Мэдэхгүй/Хариулаагүй	34.8%	25.5%	29.7%	26.4%	28.5%	26.7%
■ Үгүй	15.8%	11.2%	23.9%	22.7%	20.9%	20.3%
■ Тийм	49.4%	63.3%	46.4%	50.9%	50.6%	53.0%

Зураг 4.15: Өнгөрсөн гурван жилд Монголын бизнесийн орчинд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?



Төрийн салбар дахь авлигын төлөв байдлын талаар эрэгтэйчүүд эсвэл эмэгтэйчүүд олноор ажилладаг болон хүйсийн тэнцвэртэй харьцаатай компаниудын хооронд онцын ялгаа байхгүй байна (Зураг 4.15). Бүх бүлгүүдийн бараг тал хувь нь төрийн албанд авлига "маш их" байдаг гэж мэдээлсэн.


Зураг 4.15: Таны бодлоор төрийн салбарт хэр их авлига байна вэ? (хүйсээр)








# ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ АВЛИГА



## 5. ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ АВЛИГА


2016 оны 9 сард хувийн хэвшил дэх авлигын үнэлгээнд ихээхэн өөрчлөлт гарсан. Ерөнхийдөө 2016 онд хувийн хэвшлийн авлигын үнэлгээний түвшин нэмэгдсэн (Зураг 5.1). 2014 онд судалгаанд оролцогчдын 4.8 хувь нь хувийн хэвшилд авлига "маш их" байдаг гэж үзэж байсан бол 2016 онд энэ нь 12.4 хувь болж өссөн байна. Авлига байхгүй гэж хариулах хүмүүсийн тоо 2014 онд 25.2 хувь байснаас 2016 онд 13.6 хувь болж буурсан. "Бага зэрэг" гэсэн ангилал 3.6 хувиар нэмэгдсэн. Мэдэхгүй гэж хариулсан хүмүүсийн тоо 12.4 хувиас 19.1 хувь болж мөн өссөн байна.

Зураг 5.1: Хувийн хэвшлийн салбарт авлига хэр их байна гэж та боддог вэ?




Хувийн хэвшил дэх авлигын түвшин өссөний шалтгаан нь хувийн хэвшлийн тендер болон гэрээ байгуулах үйл явцтай хамааралтай байх магадлалтай (Зураг 5.2). Хувийн хэвшлийн тендер болон гэрээ байгуулах ажиллагаанд "огт" авлига байдаггүй гэж мэдээлэх хүмүүсийн тоо 11.8 хувиас 24.8 хувь болж өссөн байна. Эсрэгээрээ, авлига "байнга" тохиолдож байдаг гэж үзэх хүмүүсийн тоо 17 хувиас 4.5 хувь болж буурсан.

Зураг 5.2: Хувийн хэвшлийн салбарт авлига хэр их байна гэж та боддог вэ?



Өнгөрсөн онтой харьцуулахад авлига “нилээд их” тохиолддог гэж хариулсан оролцогчдын хувь хэмжээ 6.7 хувиас 4.5 хувь болж мбуурсан байна (Зураг 5.3). 2015 онтой харьцуулахад цөөн тооны оролцогчид авлига нь тэдгээрийн салбарт “байнга” тохиолддог гэж хариулжээ.

Зураг 5.3: Танай бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулахад авлига хэр их тохиолддог вэ?



Гарч буй эдгээр өөрчлөлтийг хувийн хэвшлийн орчин сайжирсан үзүүлэлт гэж дүгнэхээс илүүтэйгээр эдгээр үр дүнгүүдийн томоохон хэсэг нь авлигын тохиолдлын бодит өөрчлөлт бус эдийн засгийн үйл ажиллагаа багасаж, хүмигдсэн болон компанийн нөөцийн хомсдолтой холбоотой байж болох юм.

Үр дүнг салбаруудаар авч үзвэл "үйл ажиллагааны явцад байнга" авлигатай тулгардаг гэсэн ангиллын чиг хандлага 2015 оноос 2016 онд дараах байдлаар буурсан байна (Зураг 5.4):

Үйлчилгээ: 5 хувиас 2.9 хувь

Худалдаа: 10.7 хувиас 4.4 хувь


Үйлдвэрлэл: 10 хувиас 7.1 хувь

Барилга: 12.2 хувиас 7 хувь.


Авлигад хамгийн их автсан гэж тооцогдох барилгын салбарт судалгааны нийт хугацаанд (2012-2016) авлигатай "байнга" тулгардаг гэсэн ангиллын хамгийн их бууралт ажиглагдсан.

Зураг 54: Тэнэй бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулахад авлига хэр их тохиолддог вэ? (салбараар)


a) Үйл ажиллагааны явцад авлигатай тулгардаг: Үйлчилгээ




b) Үйл ажиллагааны явцад авлигатай тулгардаг: Худалдаа



c) Үйл ажиллагааны явцад авлигатай тулгардаг: Үйлдвэрлэл




d) Үйл ажиллагааны явцад авлигатай тулгардаг: Барилга



Татвар төлөлтийн үзүүлэлт мөн сайжирсан байна. 2015 онд судалгаанд оролцогчдын 79 хувь нь "бараг бүх" компаниуд татвар төлж байгаа гэж үзэж байсан бол 2016 онд энэ тоо бараг хоёр дахин нэмэгдсэн. Одоогоор оролцогчдын 14.5 хувь "бараг бүх" компаниуд татвараа төлдөг гэж хариулж байна (Зураг 5.5).


Зураг 5.5: Танай салбарт хэр олон компаниуд татвараа номоор нь /хууль ёсны дагуу/ төлдөг вэ?




“Бизнес Эрхлэлтийн Орчин дахь Авлигын Нөхцөл Байдал”-ын судалгааны туршид гурван салбарыг авлигад хамгийн их өртөмтгий гэж үзсэн хэвээр байна. Эдгээр нь төрийн үйлчилгээ, уул уурхай болон барилга. Төрийн үйлчилгээний авлигад өртөмтгий байдлын үнэлгээ нь 2015 онд оролцогчдын 58.2 хувиас 2016 онд 62.4 хувь болж нэмэгдсэн бол (Зураг 5.6a) нөгөө хоёр салбарын авлигад өртөмтгий байдлын үнэлгээ буурсан. Уул уурхайн салбарын хувьд 7.4 хувиар буурч 48.8 хувь болсон (Зураг 5.6b) бөгөөд барилгын салбар үзүүлэлт 6.7 хувиар буурч 41.2 хувь болсон байна (Зураг 5.6c).

Зураг 5.6: Авлигад хамгийн өртөмтгий салбарууд

a) Авлигад хамгийн өртөмтгий салбарууд: Төрийн үйлчилгээ




b) Авлигад хамгийн өртөмтгий салбарууд: Уул уурхай







с) Авлигад хамгийн өртөмтгий салбарууд: Барилга




d) Авлигад хамгийн өртөмтгий салбарууд: Санхүү




e) Авлигад хамгийн өртөмтгий салбарууд: Худалдаа



f) Авлигад хамгийн өртөмтгий салбарууд: Цахилгаан, дулаан, ус




г) Авлигад хамгийн өртөмтгий салбарууд: Үйлдвэрлэл




Компаниудыг хүйсийн харьцаагаар хүснэгтэлж үзэхэд хувийн хэвшил дэх авлигын талаарх ойлголт компаниудын хооронд ялгаатай байдаг нь харагдсан (Зураг 5.7). Эрэгтэйчүүд олноор ажилладаг компаниуд бусад хоёр бүлгийг бодвол илүү сөрөг ойлголттой байх төлөвтэй байна. Эдгээр компаниудын бараг дөрөвний нэг нь (25.8 хувь) хувийн хэвшилд авлига "маш их" эсвэл "бага зэрэг" байдаг гэж үздэг нь эмэгтэйчүүд олноор ажилладаг болон хүйсийн тэнцвэртэй харьцаатай компаниудаас өндөр үзүүлэлттэй байна (19.3 хувь ба 16 хувь).

Зураг 5.7: Хувийн хэвшлийн салбарт авлига хэр их байна гэж та боддог вэ? (хүйсээр)




# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



## 6.АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


Судалгаа хийгдэж эхэлсэн цагаас хойш авлигатай тэмцэх төрийн хүчин чармайлтын үнэлгээнд сөрөг хандлага ажиглагдаж байна. Засгийн газрын авлигатай тэмцэх арга хэмжээний талаар "өргөн мэдлэгтэй" хүмүүсийн тоо 2013 оны 10 сараас бүүрч эхэлсэн ба тухайн үед 94 хувь байснаа 2016 онд 2.1 хувь болсон байна (Зураг 6.1). Үүнтэй холбоотойгоор одоо үйлчилж буй авлигатай тэмцэх хууль "огт үр дүнгүй" гэж боддог хүмүүсийн тоо 2013 оны 10 сарын 18.8 хувиас аажмаар өссөөр 2016 онд 39.8 хувьд хүрчээ (Зураг 6.2). Төр засгаас авлигын эсрэг авч буй арга хэмжээ үр дүнтэй эсэх үнэлгээг зургаан сарын өмнөх нөхцөл байдалтай харьцуулахад "авлига буурсан" гэсэн хариулт 2013 оны 5 сард 16.4 хувиас аажмаар буурсаар 2016 онд 4.2 хувь болсон (Зураг 6.3).

Зураг 6.1: Та одоогийн Засгийн газраас явуулж байгаа авлигын эсрэг үйл ажиллагааны талаар хэр сайн мэдэх вэ?




	12 сар 2012	5 сар 2013	10 сар 2013	4 сар 2014	9 сар 2014	9 сар 2015	9 сар 2016
■ Мэдэхгүй	17.9%	9.4%	8.5%	16.4%	12.4%	19.1%	25.8%
■ Бараг мэдэхгүй	29.1%	35.2%	32.7%	35.8%	40.9%	42.1%	47.3%
■ Тодорхой хэмжээнд	43.6%	46.4%	49.4%	43.6%	42.7%	37.0%	24.8%
■ Маш их	9.4%	9.1%	9.4%	4.2%	3.9%	1.8%	2.1%

Зураг 6.2: Таны бодлоор одоо үйлчилж буй авлигын эсрэг хууль бизнесийн орчинг нээлттэй болон авлигагүй болгоход хэр нөлөөлж байна вэ?




Зураг 6.3: Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээний үр дүнд танай бизнесийн салбарын орчин зургаан сарын өмнөх байдалтай харьцуулбал ямар болсон бэ?



Монгол улсад авлигатай тэмцэхэд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд судалгаанд оролцогчдын итгэл алдарч байгаа нь харагдаж байна. 2012 оны 12 сараас хамгийн сүүлийн судалгаа хүртэл хүчин чармайлт "огт үр дүнгүй" гэсэн хариултын хувь нэмэгдэх байдал ажиглагдсан. Энэхүү үзүүлэлт нь 2012 оны 12 сард 19.4 хувь байсан бол 2016 оны 9 сард 44.5 хувь болж нэмэгджээ (Зураг 6.4). Төр засгийн зүгээс авлигад холбогдсон албан тушаалтнуудад хариуцлага тооцох чадвар болон хүсэл эрмэлзэлд нь эргэлзсэн байдал бүх цаг үеийнхээ өндөр түвшинд байна (Зураг 6.5). 2013 оны 5 сард хамгийн бага түвшин болох 39.7 хувьтай харьцуулахад 2016 оны 9 сард судалгаанд оролцогчдын 67.6 хувь Засгийн газар авлигач албан тушаалтнуудыг "хэзээ ч" шийтгэдэггүй гэж хариулсан байна.


Авлигын асуудалд холбогдож буй албан тушаалтнуудын эрх зүйн хариуцлагын талаарх хандлагад 2015 оноос эхлэн өөрчлөлт гарсан (Зураг 6.6). Өмнөх судалгаагаар оролцогчдын арай илүү хэсэг нь зөвхөн хээл хахууль авсан тал шийтгэгдэх ёстой гэж үздэг байсан бол хамгийн сүүлийн судалгаагаар өгсөн, авсан аль аль талыг шийтгэх ёстой гэж үзэх оролцогчдын тоо өсчээ. 2016 онд судалгаанд оролцогчдын 51.8 хувь хоёр тал хариуцлага хүлээх ёстой гэсэн бол 43 хувь нь зөвхөн авч буй тал хуулийн хариуцлага үүрэх ёстой гэж хариулжээ.

Зураг 6.4: Таны бодлоор Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээнүүд Монголыг авлигагүй болгоход хэр үр дүнтэй байна вэ?






Зураг 6.5: Таны бодлоор авлигад холбогдсон албан тушаалтнуудтай Засгийн газар хариуцлага тооцож чадаж байна уу?




Зураг 6.6: Зарим хүмүүс хэрвээ авлигын эсрэг хуульд зөвхөн хээл хахууль авсан хүнийг хариуцлагад татах өөрчлөлт оруулбал эерэг нөлөө үзүүлнэ гэж боддог. Зарим нь өгдөг, авдаг аль алиныг нь хариуцлагад татах хэрэгтэй гэж үздэг. Таны бодлоор:




Төрийн байгууллага дахь авлига буурах нь тэдний компанийн цэвэр орлогод нөлөөлөхгүй гэж үзэж байгаа судалгаанд оролцогчдын эзлэх хувь ихээхэн нэмэгдэж 2015 оны 26.7 хувиас 2016 онд 36.4 хувь болжээ (Зураг 6.7). Улмаар төрийн албан дахь авлига буурснаар компанийн ашиг нэмэгдэнэ гэж үзэх оролцогчдын тоо буурсан харагдаж байна.

Зураг 6.7: Хэрвээ төрийн албанд авлига багасвал танай компанийн нийт ашиг нэмэгдэх үү, буурах үү, хэвээрээ үлдэх үү?




Засгийн газраас авч буй авлигын эсрэг арга хэмжээ үр дүн багатай гэж дүгнэж байгаа ч компаниуд өөрсдөө санаачилга гаргахдаа тааруухан байсаар байна. 2016 онд судалгаанд оролцогчдын 72.4 хувь нь энэ асуудалтай тэмцэх ямар нэгэн үйл ажиллагаанд оролцоогүй гэж мэдээлсэн. Хариултын ийм түвшин бүх судалгааны түршид нийтлэг ажиглагдаж байна (Зураг 6.8). Үүнээс гадна судалгаанд оролцогчдын ердөө 9.1 хувь нь авлигын хэргийг мэдээлсэн (Зураг 6.9) бөгөөд тэдгээрийн 43.3 хувь нь мэдээлэх нь ямар нэгэн нөлөө үзүүлээгүй гэж хариулжээ (Зураг 6.10). Мөн түүнчлэн 2016 оны 9 сарын байдлаар судалгаанд оролцогчдын 78.2 хувь нь тэдний байгууллагад авлигатай тэмцэх албан ёсны журам байхгүй гэж мэдээлсэн (Зураг 6.11).


Зураг 6.8: Танай компани авлигатай тэмцэх ямар нэгэн алхам хийсэн үү?




Зураг 6.9: Та авлигын талаар мэдээлэл өгч байсан үү?



Зураг 6.10: Хэрвээ өгсөн болямар нэг үрдүнд хүрч байсан уу?



Зураг 6.11: Танай байгууллагад авлигатай тэмцэх дотоод журам бий юү?




2016 оны 9 сард авлигыг бууруулах хамгийн шилдэг туршлага болон тэдгээрийн эрэмбэ нь 2015 оны 9 сартай ижил байна (Зураг 6.12):

1. Бизнесийн зөвхөн шударга байх зарчмыг баримталдаг байх
2. Авлигач улс төрчдийн эсрэг кампанит ажил явуулах
3. Хэзээ ч хээл хахууль өгөхгүй байх
4. Засгийн газрын журам болон хуулийг мэддэг байх
5. Авлигыг АТГ-д мэдээлэлж байх


Авлигыг бууруулахад "авлигач улс төрийн нэр дэвшигчийн эсрэг кампанит ажил явуулах" арга замыг илүүд үзсэн хэвээр байна (38.8 хувь). Дараагийн судалгаагаар энэхүү хандлага сонгуулийн онуудын (2015-2016) дараа ч гэсэн хэвээр байвал авлигын эсрэг арга замуудын дундаас тогтмол байр суурьтай болох магадлалтай байна.

Зураг 6.12: Хувийн хэвшил дэх авлигыг бууруулах шилдэг таван арга зам (3 сонголт зөвшөөрсөн байна).



Авлигатай тэмцэх газрын бизнес дэх авлигыг бууруулах хүчин чармайлтыг оролцогчид маш багаар үнэлсэн. Тэдгээрийн аравны нэг хүрэхгүй хувь АТГ-ын үйл ажиллагаанд эерэг үнэлгээ өгсөн бол оролцогчдын талаас илүү хувь сөрөг үнэлгээ өгсөн байна (тус бүр 7.9 хувь ба 52.1 хувь).

Зураг 6.13: Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ



# СУДАЛГААНД АШИГЛАСАН АСУУЛГА

## Хувийн хэвшилийн салбар дахь авлигын талаарх ойлголт

01. Бизнес эрхлэгч байгууллагын дугаар: \_\_\_\_\_ 02. Дүүрэг \_\_\_\_\_

### А.Бизнес эрхлэгч байгууллагын талаарх мэдээлэл

1. Үүсгэн байгуулсан огноо: \_\_\_\_\_
2. Бизнес эрхлэгч байгууллагын үйл ажиллагааны гол чиглэл:

1	Үйлчилгээ	
2	Худалдаа	
3	Үйлдвэрлэл	
4	Барилга угсралт	
5	Уул уурхай	
6	Хөдөө аж ахуй	
7	Бусад (тодорхойлно уу) _____	

3. (А) Ажилчидын тоо (байнгын) \_\_\_\_\_  
(В) Танай ажилчдын хэдэн хувийг эрэгтэй, хэдэн хувийг эмэгтэй эзэлдэг вэ?

Хүйс	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.	10.	11.
Эр	100%	90%	80%	70%	60%	50%	40%	30%	20%	10%	0%
Эм	0%	10%	20%	30%	40%	50%	60%	70%	80%	90%	100%

4. (А) Жилийн эргэлтийн хөрөнгө \_\_\_\_\_  
(В) 1) 150,000,000 төгрөг-с бага  
2) 150,000,000 MNT - 2,000,000,000-аас бага  
3) 2,000,000,000 төгрөг болон түүнээс их

### В.Алдагдал

5.	Танай байгууллагын удирдлага үйлдвэрлэлийн бус асуудлуудыг жич: зөвшөөрөл, лиценз шинэчлэх буюу шинээр авах, албан ёсны хариу хүлээх гэх мэт, шийдвэрлэхэд ажлын цагийн хэдэн хувийг зарцуулдаг вэ?	Огт үгүй	1.
		25% хүртэл	2.
		25- 50%	3.
		50%-иас их	4.
		(Мэдэхгүй)	5.

6.	Үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд байгууллагын нөөцийн хэдэн хувийг урашиггүй зарцуулдаг вэ?	Огт үгүй	1.
		10% хүртэл	2.
		10-25%	3.
		25%-иас их	4.
		(Мэдэхгүй)	5.

### С.Бизнес эрхлэлтийн нөхцөл байдал

7.	Та Монгол дахь бизнес эрхлэлтийн ерөнхий орчинд сэтгэл хангалуун байдаг уу, үгүй юу?	Маш хангалуун	1.
		Харьцангуй хангалуун	2.
		Хангалуун биш	3.
		Огт хангалуун биш	4.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	5.

8.	Өнгөрсөн хагас жилд танай компанийн үйл ажиллагаатай холбогдсон хөрөнгө оруулалт ерөнхийдөө.....	Өссөн	1.
		Хэвээрээ	2.
		Багассан	3.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	4.

9.	Та компанийн үйл ажиллагааныхаа хөрөнгө оруулалтыг ирэх 6 сарын хугацаанд.....	Нэмнэ	1.
		Байгаа хэмжээнд нь үлдээнэ	2.
		Багасгана	3.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	4.

### 10. Хөрөнгө оруулалтын гол бэрхшээлүүд нь юу байна вэ? (3 хүртэл сонгоно уу)

Өндөр татвар	1	Бусад компаниудаас үзүүлж байгаа хүчтэй өрсөлдөөн	10
Албан хураамж	2	Стандартчилалын шаардлага	11
Албан бус хураамж	3	Хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал /хомсдолтой/	12
Түр зуурын хориг, саад	4	Зээл авах боломж	13
Байнгын хориг, саад	5	Менежментийн сургалт хангалттай бус	14
Мэдээллийн хүртээмж болон чанар	6	Зах зээлийн судалгаа хангалттай бус	15
Зөвшөөрөл, лиценз олголт, сунгалт	7	Өөр /тодруулна уу/:	16
Ажиллах хүчний мэргэжлийн чадвар хангалтгүй	8	(Хөрөнгө оруулалтын бэрхшээл байхгүй)	98.
Тээврийн хүртээмж, үнэ	9	(Мэдэхгүй/Хариулаагүй)	99.



11.	Дараах байгууллагуудын аль нь танай салбарын бизнест хамгийн их саад учруулдаг вэ?	Мэргэжлийн хяналтын газар	1.
		Газар, кадастрын алба	2.
		Цагдаа	3.
		Татварын алба	4.
		Гааль	5.
		Хот тохижилтын алба	6.
		Ариун цэврийн алба	7.
		Орон нутгийн захиргаа	8.
		Өөр (тодруулна уу):	9.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	10.

11a.	Таны ажиглалтаар бизнесийн үйл ажиллагааны явцад дараах төрийн алба, агентлаг уудын аль нь хамгийн их авлигад өртөгдсөн бэ?  (Нэгээс гурван хариулт сонгоно уу)	Мэргэжлийн хяналтын газар	1.
		Гадаадын иргэн харьяатын газар	2.
		Газар, кадастрын алба	3.
		Цагдаа	4.
		Татварын алба	5.
		Гааль	6.
		Шудрага өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	7.
		Ашигт малтмалын газар	8.
		Нийгмийн халамж, үйлчилгээний газар	9.
		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	10.
		Засгийн газрын худалдан авах ажиллагааны газар	11.
		Өөр /тодруулна уу/:	12.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	13.

#### D.Төрийн түвшиний авлига

12.	Таны бодлоор төрийн түвшинд хэр их авлигатай байна вэ?	Маш их	1.
		Нилээд	2.
		Бага зэрэг	3.
		Байхгүй	4.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	5.

13.	Танай салбар дахь төр болон хувийн компанийн харилцаанд авлигын чанартай зүйл байгааг та хамгийн сүүлд хэзээ ажигласан бэ?	Сүүлийн сард	1.
		Өнгөрсөн 23 сард	2.
		4-6 сарын өмнө	3.
		7-12 сарын өмнө	4.
		Жилийн өмнөөс илүү	5.
		Тийм тохиолдол хэзээ ч гараагүй	6.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	7.

14.	Таны бодлоор төрийн тендерийн болон гэрээ байгуулах ажиллагаанд авлига хэр их тохиолддог вэ?	Байнга	1.
		Нилээд	2.
		Хааяа	3.
		Хэзээ ч гардаггүй	4.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	5.

15.	Төрийн авлига танай бизнест шууд нөлөөлж байна уу?	Тийм	1.
		Үгүй (Асуулт 17 хүртэл алгасах)	2.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	3.

16.	Хэрвээ тийм бол хэр их нөлөөлж байна вэ?	Маш	1.
		Нилээд	2.
		Бага зэрэг	3.
		Огт үгүйх	4.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	5.

17.	Та одоогийн Засгийн газраас явуулж байгаа авлигын эсрэг үйл ажиллагааны талаар хэр сайн мэдэх вэ?	Маш их	1.
		Тодорхой хэмжээнд	2.
		Бараг мэдэхгүй	3.
		Огт мэдэхгүй	4.

18.	Таны бодлоор одоогийн үйлчилж байгаа авлигын эсрэг хууль бизнесийн орчинг нээлттэй болон авлигагүй болгоход хэр нөөцөлж байна вэ?	Маш их	1.
		Нилээд	2.
		Бага зэрэг	3.
		Огт үгүй	4.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	5.

19.	Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээний үр дүнд танай салбарын орчин 6 сарын өмнөх байдалтай харьцуулбал ямар болсон бэ?	Авлига багассан	1.
		Хэвээрээ байна	2.
		Нэмэгдсэн байна	3.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	4.

20.	Ерөнхийд нь авч үзвэл Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээнүүд Монголыг авлигагүй болгоход хэр үр дүнтэй байна вэ?	Маш үр дүнтэй	1.
		Нилээд	2.
		Бага зэрэг	3.
		Огт үр дүнгүй	4.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	5.

21.	Авлигад өртсөн албан тушаалтнуудыг Засгийн газар хэрхэн хариуцлагад татаж чадаж байна гэж та боддог вэ?	Байнга	1.
		Ихэнх тохиолдолд	2.
		Хааяа	3.
		Чадахгүй байна	4.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	5.

Д22.	Таны бодлоор Их авлига буюу дээд түвшний авлига Таны бизнест хэр зэрэг нөлөөлж байна вэ?	Маш их	1.
		Тодорхой хэмжээд	2.
		Бага зэрэг	3.
		Огт үгүй	4.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	5.

Д23	Таны бодлоор төрийн авлигын сүлжээ голдуу хувь хүмүүсийн хоорондын харилцааны хүрээнд тархан байна уу, эсвэл зохион байгуулалттай бүлэглэлийн хэмжээнд очсон байна уу?	Голдуу зохион байгуулалттай бүлэглэлийн хэмжээнд очсон байна	1.
		Голдуу хувь хүмүүсийн хоорондын харилцааны хүрээнд	2.
		Хоёр хэлбэр тэнцүү байдалтай байна	3.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	4.

**Е.Хувийн хэвшлийн авлига**

22.	Хувийн хэвшлийн салбарт авлига хэр их байна гэж та боддог вэ?	Маш их	1.
		Нилээд	2.
		Бага зэрэг	3.
		Байхгүй	4.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	5.

23.	Хувийн хэвшлийн тендерийн болон гэрээ байгуулах ажиллагаанд авлига хэр их гардаг вэ?	Байнга	1.
		Нилээд	2.
		Хааяа	3.
		Хэзээ ч гардаггүй	4.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	5.

24.	Танай бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулахад авлига хэр их тохиолддог вэ?	Байнга	1.
		Нилээд	2.
		Хааяа	3.
		Хэзээ ч гардаггүй	4.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	5.

25.	Танай салбарт хэр олон компаниуд татвараа номоор нь /хууль ёсны дагуу/ төлдөг вэ?	Бүгдээрээ	1.
		Дийлэнх нь	2.
		Зарим хэд нь	3.
		Цөөн хэд нь	4.
		Номоор нь төлдөг газар байхгүй	5.

**26. Дараах салбаруудын аль нь авлигад хялбар өртдөг вэ? (Нэгээс гурван хариулт сонгоно уу)**

Уул уурхай	1
Барилга	2
Үйлдвэрлэл	3
Цахилгаан, халаалт, усан хангамж	4
Худалдаа	5

Банк санхүү	6
Өөр /хувийн хэвшлээс/:	7
Төрийн үйлчилгээ	8
Мэдэхгүй	9

E27.	Өнгөрсөн гурван жилд Монголын бизнесийн орчинд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?	Ихээхэн өссөн	1.
		Бага зэрэг өссөн	2.
		Хэвээр үлдсэн	3.
		Бага зэрэг буурсан	4.
		Ихээхэн буурсан	5.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	6.

### Ғ. Төрийн байгууллагын тендерүүд

ADB1	Танай компани төрийн байгууллагын тендерүүдэд оролцдог уу?	Тийм	1.
		Үгүй	2.

ADB2	Таны бодлоор улс төр, гэр бүлийн харилцаа тендерийн үр дүнд нөлөөлдөг үү?	Тийм	1.
		Үгүй	2.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	3.

ADB3	Одоо ЗГХАА- Засгийн газрын худалдан авах ажиллагааны газар нь засгийн газрын худалдан авалтыг хариуцан ажиллаж байна. Ийм тохиолдолд та тендерт оролцох үү?	Тийм	1.
		Үгүй	2.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	3.

### Г. Авлигатай тэмцэх

G27.	Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг та хэрхэн үнэлж байна вэ?	Их сайн	1.
		Харьцангуй сайн	2.
		Сайн ч биш, муу ч биш	3.
		Тааруухан	4.
		Муу	5.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	6.

27.	Зарим хүмүүс хэрвээ авлигын эсрэг хуулинд зөвхөн авлига авсан хүнийг хариуцлагад татах өөрчлөлт оруулбал засаглалд эерэг нөлөө үзүүлнэ гэж боддог. Зарим нь өгдөг, авдаг аль алиныг нь хариуцлагад татах хэрэгтэй гэж үздэг. Таны бодлоор:	Зөвхөн авдаг хүмүүс хариуцлагад татагдах ёстой	1.
		Аль алиныг нь хариуцлагад татах хэрэгтэй	2.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	3.

28.	Хэрвээ төрийн авлига багасвал танай компанийн нийт орлого нэмэгдэх үү, буурах үү, хэвээрээ үлдэх үү?	Нэмэгдэнэ	1.
		Хэвээрээ үлдэнэ	2.
		Буурна	3.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	4.

29.	Танай компани авилгатай тэмцэх ямар нэгэн алхам хийсэн үү?	Тийм	1.
		Үгүй	2.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	3.

30.	Та авлигын талаар мэдээлэл өгч байсан үү?	Тийм	1.
		Үгүй (Асуулт 31 хүртэл алгасах)	2.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	3.

30a.	Хэрвээ өгсөн бол ямар нэг үр дүнд хүрч байсан үү?	Тийм	1.
		Үгүй	2.
		Зарим тохиолдолд хүрч байсан/ зарим тохиолдолд хүрч байгаагүй	3.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	4.

31.	Танай байгууллагад авлигатай тэмцэх дотоод журам бий юу?	Тийм	1.
		Үгүй	2.
		(Мэдэхгүй/Хариулаагүй)	3.

32. (Хувийн хэвшлийн талаас) Улс орныг авлигагүй болгох ямар арга зам сонгох хэрэгтэй вэ?

(Нэгээс гурван хариулт сонгоно үү)

Хахууль хэзээ ч өгөхгүй	1
Шудрага зарчимаар ажиллах	2
Авлигатай тэмцдэг ТББ-д элсэх	3
Засгийн газрын үйл ажиллагааны талаарх хууль, дүрмийн мэдлэгтэй байх	4
Хэвлэл мэдээллийнхэнд авлигын талаар мэдээ өгөх	5

АТГ-т мэдээлэх	6
Авлигач улс төрчдийн эсрэг компани арга хэмжээ явуулах	7
Өөр /тодруулна уу/:	8
(Мэдэхгүй/Хариулаагүй)	9



